



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АЖИЛ “МАХ ИМПЕКС” ХК-ИЙН

2025 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн дуусгавар тайлан

Улаанбаатар хот

2026 он



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

15171 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бакули Ринбүүчийн гудамж, Оршил-2 төв, 5 дэвхар,
Утас: 9908 5151, 9199 1462, Факс: (976-11) 32 52 62,
И-мэйл: byambaa@lumina@yahoo.com, Вэб: www.dumaudil.mn

2026.04.14 № 79
танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Хүлээн авах хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот
Сонгинохайрхан дүүрэг 18100, 4-р хороо
Хүнсчидийн гудамж, Өөрийн байр

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан Дүгнэлт

Бид 2025 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Мах Импекс ХК-ний санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар Мах Импекс ХК -ний 2025 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн орлогын дэлгэрэнгүй ба мөнгөн гүйлгээ, өмч өөрчлөлтийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яамнаас батлан гаргасан заавар журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба элгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад Мэдээлэл

Энэхүү компани нь бусад мэдээлэл буюу үйл ажиллагааны жилийн тайлан бэлтгэдэггүй. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхийн Этгээдүүдийн Санхүүгийн Тайланг хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад бидэнд танилцуулангүй баримт материалаас үүдэх эрсдлийг компанийн хариуцлага гэдгийг удирдлагад сануулсан болно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээн Аудиторын Үүрэг Хариуцлага


Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлан бэлтгэх явдал юм.


Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар компаниас ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал, зөрчлийн талаарх асуудлыг зөвлөмжөөр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

1 тайлангийн хэрэглээ

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа нэг гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.


ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ ЧД 2 ХОРОО
БАКУЛА ГИНЬҮҮЧИЙН 1 УДАМЖ
ОРШИЛ 2 ТӨВ 5 ДАВХАРТ
 Огноо: 2026.04.14



Мах импекс ХК
2025 оны санхүүгийн тайлангийн
бодит байдлын тухай мэдэгдэл

2025 оны 12 - р сарын 31-ны өдөр

Гүйцэтгэх захирал Г.Будрагчаа, нягтлан бодогч С.Мөнхжаргал бид манай аж ахуйн нэгжийн 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хутагааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг " Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 9.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.Будрагчаа



НЯГТЛАН БОДОГЧ

С.Мөнхжаргал

манай байгууллагын 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид санхүүгийн тайлангаа холбогдох санхүүгийн тайлагналын стандарт болон заавар журмын дагуу бэлтгэсэн талаар саналаа илэрхийлэх зорилгоор энэхүү захидлыг бичиж байна. Бид санхүүгийн тайлангаа холбогдох санхүүгийн тайлагналын стандарт болон заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй гэдгээ баталгаажуулж байна.

Энэ захидалд харуулсан зарим зүйлүүд нь материаллаг гэж үзэх боломжгүй байж болох юм. Учир нь бид санхүүгийн тайлангийн хэрэглэгчийн шийдвэрт нөлөө үзүүлэхүйц алдаа эсвэл буруу тайлагналыг материаллаг гэж үзсэн.

Бид 2026 оны 03 сарын 31-ний өдрийн байдлаар өөрсдийн мэдлэг, итгэл үнэмшлийн дагуу дараах зүйлүүдийг баталгаажуулж байна.

- Бид санхүүгийн тайлангуудыг холбогдох санхүүгийн тайлагналын стандарт, заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн.
- Бид санхүүгийн холбогдолтой бүх данс бүртгэл, тоо дүн, бүх шатны удирдлагын хурлын тэмдэглэл болон саяхан болсон боловч хараахан бэлтгэгдээгүй байгаа хурлын тэмдэглэл зэрэг бүх мэдээллээр хангасан.
- Санхүүгийн тайлагналтай холбоотой аливаа хууль бус үйл ажиллагаа явуулсан талаар холбогдох байгууллагаас мэдээлэл ирээгүй.
- Бүртгэл тайланд тусгагдаагүй аливаа материаллаг ажил гүйлгээ байхгүй.
- Удирдлага болон бусад гүйцэтгэх ажилтнуудтай холбоотой залилан эсвэл санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх залилантай холбоотой нөхцөл байдал үүсээгүй.
- Холбоотой талуудын ажил гүйлгээ, бүх гол чухал тооцоолол, удирдлагаас тодруулах ёстой материаллаг шинжтэй бүх зүйлсийг санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт бүрэн тусгасан.
- Санхүүгийн тайланд тодруулагдах ёстой хууль зөрчсөн үйл ажиллагаа болон шүүхийн томоохон хэмжээний зарга маргаан, ирээдүй үеийн өр төлбөртэй холбоотой асуудал үүсээгүй.
- Байгууллага нь бүх хөрөнгийнхөө хувьд хууль ёсны эзэмшлийн гэрчилгээтэй бөгөөд хөрөнгийг хууль бусаар ашиглах гэх мэт үйл ажиллагаатай холбоотой зүйл гараагүй.
- Санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлөх бүх гэрээ хэлэлцээрүүдийг бид дагах мөрдсөн.
- Тайлагналын өдрийн дараах аливаа үйл явдал тохиолдоогүй бөгөөд энэхүү захидал бэлтгэсэн өдрийн байдлаар залруулга болон тодруулга шаардлагатай ажил гүйлгээ гараагүй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

/Г.БҮДРАГЧАА/
/С.МӨНХЖАРГАЛ/



01. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Мах Импекс ХК (цаашид “компани” гэх) нь 1946 онд Боловсон мах комбинат нэртэйгээр анх ашиглалтад орсон Монгол Улсын анхны махны үйлдвэрүүдийн нэг юм 1999 онд хувьцаат компани болон өөрчлөгдөж бизнес технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэн мах махан бүтээгдэхүүн боловсруулалт, худалдаа, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Мах Импекс ХК нь эх орныхоо байгалийн бэлчээрээс бэлтгэсэн сайн чанарын малын гаралтай бүтээгдэхүүнээр дагнасан мах боловсруулах, экспортлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Мах импекс ХК нь түүхт 80 жилийн ойн хүрээнд үйлдвэр болон зоорийн бүрэн шинэчлэлийг Австрийн “Bersch Laska” компанитай хамтран 3 үе шаттай МИК-80 төслийг 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Компанийн тухай хуульд заасны дагуу нээлттэй буюу хувьцаат компани статустай, Регистр 2069229, Улсын бүртгэлийн гэрчилгээ 9010001046 дугаартай 1 гишүүнтэй 380,072.1 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй нийт гишүүдийн тоо 9891 байна.

Тус компани нь өнгөрсөн хугацаанд дотоодод болон экспортын борлуулалт нийлээд 103,481,660.1 мянган төгрөг, нөөцийн мах нийт 837.0 тн-ийг нийслэлийн хүн амын махны хэрэгцээнд гэрээний дагуу нийлүүлсэн байна.

“Мах импекс” ХК нь Монголын хөрөнгийн биржийн ангилалд багтдаг нээлттэй хувьцаат компани бөгөөд эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. Компанийн ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн дарга Г.Цэнгүүн ажиллаж байна.

Компани бүтэц орон тоогоор 143 байнгын ажлын байранд 120 ажилтан албан хаагчидтай ажиллаж байна. Компани нь захиргаа, санхүү, борлуулалт, МБҮ, машин танхим, сантехник, цахилгаан, засвар, автограш гэсэн цех нэгжүүдтэй.

КЭБАТ-ЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Галсан Бүдрагчаа	Гүйцэтгэх захирал	0 %
2	С. Мөнхжаргал	Ерөнхий нягтлан бодогч	0 %

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Овог Нэр	Гишүүнчлэл	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Г.Цэнгүүн	ТУЗ-ийн дарга	0 %
2	Б.Оргилболд	ТУЗ-ийн гишүүн	11.3 %
3	Ж.Баттөр	ТУЗ-ийн гишүүн	0 %
4	Б.Намуун	ТУЗ-ийн гишүүн	0 %
5	Х.Цэндбаяр	ТУЗ-ийн гишүүн	0 %
6	Б. Саруул	ТУЗ-ийн гишүүн	0 %
7	Т.Золбаяр/Хараат бус	ТУЗ-ийн гишүүн	0 %
8	Б.Оргил/Хараат бус	ТУЗ-ийн гишүүн	0 %
9	М.Лхачинбал /Хараат бус	ТУЗ-ийн гишүүн	0 %

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

№	Овог Нэр	Эзэмшил хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшил бүтэц байдал	Түүнтэй нэгдмэл санхүүжилтэй эгнээ
1	Баянгол зочид буудал ХК	12.49 %	Байхгүй	Байхгүй
2	Халтмаа Баттулга	38.78 %	Байхгүй	Байхгүй
3	Баттуул Оргилболд	11.26 %	Байхгүй	Байхгүй
4	Баттуул Оргилбат	8.25 %	Байхгүй	Байхгүй

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ТҮҮХ

№	Овог Нэр	Эзэмшил байсан хувьцааны хувь	Эзэмшил байсан огноо
1	Б.Оргилболд	11.26 %	2021-05-18
2	Х.Баттуул	5.43 %	2018-09-25
3	Х.Баттулга	38.78 %	2017-08-03

Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн.

Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд: $ROA=4.3\%$, $ROE=21.4\%$

$EPS=548.2$, $ROTA=1.17$

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Нийт хөрөнгө- 65,238,295,589.34
- Өр төлбөрийн нийт дүн- 49,897,430,659.02
- Эзэмшигчдийн өмчийн дүн- 13,340,864,730.32
- Нийт гаргасан хувьцаа- Байхгүй

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Нийт борлуулалтын орлого -103,481,660,128.97
- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг-97,957,310,339.31
- Нийт ашиг- 5,524,349,789.66
- Цэвэр ашиг- 3,992,078,864.94
- Ногдол ашиг /энгийн/-100
- Ногдол ашиг /давуу эрхийн/-0
- Нэгж хувьцааны дансны үнэ-2,091.3 төгрөг

"Мах Импекс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн №05 тоот тогтоолоор 2025 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 100 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болсон байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоох бөгөөд 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрөөс үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан олгохоор шийдвэрлэсэн байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Тус компани нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 361 дугаар "Маягт заавар батлах тухай" тушаалын Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" 1 дүгээр, "Санхүүгийн тайлангийн А маяг"-ыг 2 дугаар хавсралтуудыг үндэслэн бэлтгэсэн.

Компанийн хувьцаа эзэмшигчид компанийн өр төлбөрийг барагдуулах хангалттай мөнгөн хөрөнгөтэй байлгахыг хүлээн зөвшөөрдөг учраас компани санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаар компани 3,992,078,864.94 төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, компанийн нийт хөрөнгө /63,238,295,389.34төгрөг/ нийт өр /49,897,430,659.02төгрөг/ төлбөрөөсөө 13,340,864,730.32 төгрөгөөр өөрийн хөрөнгө их байна. Үүнээс харахад компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, тогтвортой явуулах боломжтой.

Стандартын баримтлал ба хэрэгжүүлэлт

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол Улсын зохих хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн байна.

Гадаад валютын хөрвүүлэлт

Санхүүгийн тайланг төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг юм. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн валютаар болон гүйлгээ хийгдэх үеийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн, төгрөг/валютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгө, тооцооны данстыг балансын дуусгавар болсон өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэсэн. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээгээс үүссэн зөрүүг орлогын тайланд тусгагддаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг түүхэн өртгөөр нь тооцож, тухайн ажил гүйлгээ анх гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тогтоосон өдрийн ханшаар хөрвүүлэн балансаа тусгадаг.

Холбоотой талууд

Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд холбоотой талууд оршин байдаг ч хяналтын эрхгүй, санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцдог.

Зээлийн хүү

Зээлийн хүүг анх бүртгэхдээ нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаа бүрд анх бүртгэсэн нэрлэсэн үнэ болон зээлийн хүүг төлсөн үеийн үнийн зөрүүгээр хорогдуулж зээлийн хугацаанд үүссэн олз, гарзыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хүүгийн аргыг ашиглан орлого үр дүнгийн тайланд ашиг, алдагдлаар тусгана.

Зээл болон зээлийн хүү

Зээл олгосон банк байгууллага	Валют	Үндсэн зээл /мян.төг/	Хугацаа	Төлөх зээлийн хүү	Зээлийн ашиглалт
ХХБ	₮	10,000,000.0	12 сар	525,000.0	Нөөцийн мах бэлтгэл
ХХБ	Юан	10,063,986.0	12 сар		Хөрөнгө оруулалт

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар доорх заалтуудыг мөрдлөг болгон ажиллах.

14.1. Энэ хуулийн 8.1.1-д заасан үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх, түүнчлэн эд хөрөнгө худалдан авах зорилгоор авсан зээлийн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

14.2. Албан татвар төлөгч аж ахуйн нэгжийг хяналтдаа байлгадаг Монгол Улсад байнга оршин суугч хувь хүнээс авсан зээлийн хүүгийн төлбөрийг тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй бөгөөд энэ зардлыг зээл олгосон тухайн хувь хүний ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.

Санхүүгийн тайлан тодруулга, НББ-ын программ хангамжийн талаар.**1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө ба банкин дахь харилцах данстуудаас бүрддэг. Мөнгөн хөрөнгийг банканд байлгах нь ямар нэг эрсдэл агуулахгүй. Харин мөнгөн хөрөнгө нь бэлнээр хадгалах гүйлгээ хийх нь эрсдэлийг дагуулж байдгийг анхаарах хэрэгтэй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад

валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

Бэлэн мөнгөний тооллогын үлдэгдэл кассын бүртгэлийг нотломж, үлдэгдлийн баталгаажилт сар бүр хийх, банкны харилцах данстын эцсийн үлдэгдэл болон дансны хуулга баталгаажилт ханган ажиллахыг сануулж байна. Валютын данстын гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэх, тухайн үеийн дансны валютын тэгшитгэлийн бичилтийг дахин шалган үлдэгдлийг үнэн зөв тусган залруулах шаардлагатай байна.

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	2025.01.01	2025.12.31
Касс дахь мөнгө	116,730,816.66	5,086,838.59
Банкин дахь мөнгө	1,598,915,153.77	18,429,338.70
Нийт дүн	1,715,645,970.43	23,516,177.29

Касс, банкны харилцах данстын дэлгэрэнгүйг харуулбал:

Үзүүлэлт	Дансны дугаар	Валютын төрөл	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
Кассанд байгаа бэлэн мөнгө (төгрөг)	1001-003-000-00-00	MNT	119,223,830.51	16,136,331,923.58	16,250,612,365.00	4,943,389.07
Кассанд байгаа бэлэн мөнгө (валют)	1002-003-000-00-00	USD	143,440.52	-	-	143,440.52
			304.00	-	-	304.00
Кассанд байгаа бэлэн мөнгө (валют)	1002-003-000-00-00	USD	(2,636,463.37)	56,516,698.18	53,880,234.81	-
			(773.00)	15,773.00	15,000.00	-
Касс дүн :			116,730,816.66	16,192,848,621.74	16,304,492,599.81	5,086,838.59
Худалдаа хөгжлийн банк 499001028	1101-003-000-00-01	MNT	58,959.88	16,370,603,384.27	16,370,454,044.83	208,299.32
Худалдаа хөгжлийн банк 499051274	1101-003-000-00-07	MNT	5,924.38	-	5,924.38	-
ХААН банк Хүлэг 5030078555	1101-003-000-00-12	MNT	980,458,836.98	16,283,002,810.52	17,245,961,038.41	17,500,659.09
ХААН банк 1705000868	1101-003-000-00-15	MNT	633,397.35	8,016,602.65	8,650,000.00	-
Голomt Банк 8115006487 /мөсгийн маркны данс /	1101-003-000-00-18	MNT	(9,142.86)	-	-	(9,142.86)
Худалдаа хөгжлийн банк 412041275	1101-003-000-00-20	MNT	622,384,953.14	81,542,329,584.23	82,164,181,965.81	532,571.56
Төгрөгийн дүн :			1,603,532,978.87	114,203,952,381.67	115,789,252,973.43	18,232,387.11
Худалдаа хөгжлийн банк 409051285	1102-003-000-00-02	USD	(4,967,054.23)	4,054,685,740.42	4,049,716,767.50	11,002.32
			114.28	549,625.06	549,739.34	-
Хүлэг - хаан банк 5030240190	1102-003-000-00-07	USD	27,114.99	32,983.58	55,901.71	4,196.86
			7.95	-	6.77	1.18
ГОЛОМТ (RUB)- 8115100152	1102-003-000-00-09	RUB	(0.58)	-	-	(0.58)
			-	-	-	-
ХААН Банк 5101002076	1102-003-000-00-10	RUB	(2,646.31)	-	-	(2,646.31)
			(69.53)	-	-	(69.53)
Худалдаа хөгжлийн банк 412050470	1102-003-000-00-12	EUR	122,856.63	134,067,948.45	134,058,371.77	132,433.31
			35.49	31,732.03	31,737.98	29.54
Худалдаа хөгжлийн банк 412026047	1102-003-000-00-13	CNY	91,904.40	30,684,073,421.44	30,684,114,255.86	51,069.98
			196.00	61,509,207.96	61,509,303.63	100.33
Валютын дүн :			(4,617,825.10)	32,772,760,063.69	32,767,945,286.90	196,951.59
Нийт мөнгөн хөрөнгийн дүн			1,715,645,970.43	163,169,561,067.00	164,861,690,860.14	23,516,177.29

Дансны авлагыг

Үзүүлэлт	Дансны авлагыг	Нийт дүн	Дансны авлагыг цэвэр дүнгээр
Эхний үндэсдэл	14,348,032,207.83		14,348,032,207.83
Хувь нэмэлт	69,217,084,718.50		69,217,084,718.50
Хувиарсан	69,034,862,474.16		69,034,862,474.16
Хувиарсан	69,034,862,474.16		69,034,862,474.16
Эхний үндэсдэл	14,530,254,452.17		14,530,254,452.17

Авлагыг нь үүссэн тухайн үеийн нэхэмжлэгдэх дүнгээр бүртгэгдсэн. Авлагын хувьд нийтлэл, нутагшуулах магадлалыг үнэлэн нөхдрийн сан байгуулаагүй. Дансны авлагыг нөхдөр амьтсан итгээр баталгаажуулан ажилладаг байна.

Дансны авлагыг дэлгэрэнгүй бүртгэлийн тохируулах бичилтүүд хийгдсэн.

Дэлгэрэнгүй тооцооллыг нарийвчлан хийгээгүй тул холбогдох татварын албатай авлагыг нөхдөр нийлсэн актаар баталгаажуулан ажиллахыг сануулж байна.

Авлагыг онд МИК-80 төслийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор урьдчилж төлсөн зардалыг нөхдөр 59.5 хувь буюу 13,769,987.7 мянган төгрөгөөр нэхэгдсэн байна.

Борлох материал

Борлох материалыг цэвэр боломжтой үнэ цэнэ буюу цэвэр боломжтой өртгөөр нь бүртгэгдэх. Цэвэр боломжтой үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар зориулсан үнэ цэнийг нөх бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад тооцсон зардлыг нөхдөр дүн юм.

Үзүүлэлт	Түүхийг эд	Хангамжийн материал	Нийт дүн
Эхний үндэсдэл	4,694,632,084.94	1,130,516,865.93	5,825,148,950.87
Хувь нэмэлт дүн	220,424,463,194.37	1,065,180,795.28	221,489,643,989.65
Хувиарсан дүн	219,397,606,836.27	1,061,231,734.67	220,458,838,570.94
Эхний үндэсдэл	5,721,488,443.04	1,134,465,926.54	6,855,954,369.58

Борлох материалын байнгын систем ашигладаг ба дундаж өртгийн аргыг хэрэглэдэг.

Борлох материалын хувьд худалдан авалтын тооцоог талбарийн баримттай тулган шалгах шаардлага байх шаардлагатай.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан эзлэгдэх болон хуримтлагдсан үнэ цэнийг бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг ба үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг болон хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаргах зардалас бүрддэг.

Үзүүлэлт	Барилга байгууламж	Машин, тэрэгнүүд	Компьютер, бусад хэрэгсэл	Нийт дүн
Үндсэн хөрөнгө /өртөг/	-	-	-	-
Эхний үндэсдэл	5,713,937,052.06	4,057,500,468.55	17,643,836.36	9,789,081,356.97
Хувиарсан дүн	1,342,367,486.29	653,114,384.13	26,473,750.00	2,023,975,820.42

Худалдаж авсан, өөрөө барьж байгуулсан	1,342,387,486.29	653,114,384.13	28,473,750.00	2,023,975,620.42
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	-	-	-	-
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	-	-	-	-
Зээл, тусламж хандиваар	-	-	-	-
Бусад	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
Хасагдсан дүн (-)	-	-	-	-
Худалдсан	-	-	-	-
Үнэгүй шилжүүлсэн	-	-	-	-
Акталсан	-	-	-	-
Бусад	-	-	-	-
Үндсэн хөрөнгө дахин ангилсан	-	-	-	-
Үндсэн хөрөнгө, ХОЗҮХХ хооронд дахин ангилсан	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	5,056,324,538.35	4,710,614,852.68	46,117,388.36	9,813,056,777.39
ХУВИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-	-	-	-
Эхний үлдэгдэл	2,442,374,651.43	2,857,812,472.01	5,754,120.69	5,305,941,244.13
Нэмэгдсэн дүн	171,844,363.39	307,502,201.56	10,838,139.54	490,184,704.49
Байгуулсан элэгдэл	171,844,363.39	307,502,201.56	10,838,139.54	490,184,704.49
Дахин үнэлгээгээр нэмэгдсэн	-	-	-	-
Үнэ цэнийн бууралтын буцаалт	-	-	-	-
Хасагдсан дүн	-	-	-	-
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	-	-	-	-
Дахин үнэлгээгээр буурсан	-	-	-	-
Үнэ цэнийн бууралт	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	2,614,219,014.82	3,165,314,673.57	16,592,260.23	5,796,125,948.62
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН	-	-	-	-
Эхний үлдэгдэл	1,271,562,400.63	1,199,687,996.54	11,889,515.67	2,483,139,912.84
Эцсийн үлдэгдэл	2,442,105,523.53	1,545,300,179.11	29,525,126.13	4,016,930,828.77

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцож, элэгдэл байгуулдаг бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацааг нарийвчлан тогтоон элэгдлийг байгуулж өртөгт хуваарилан тооцсон байна. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланг гүйлгээ балансын дүнтэй дахин нягтлан үзэх.

Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөнд 4,810.3 мянган төгрөгийн компьютер программ хангамжийг бүртгэсэн байна.

Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөр нь тайлант хугацаанд үүссэн бараа, үйлчилгээний худалдан авалт, үйл ажиллагааны зардал, татвар, шимтгэл, цалинтай холбогдох өглөг бөгөөд тэдгээрийг үүссэн тухайн үеийн нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Улсын байгууллагад төлөх өр	Хувийн байгууллагад төлөх өр	Эцсийн үлдэгдэл
Дансны өглөг	36,404,072,517.61	-	47,209,627,977.49	47,209,627,977.49
Цалингийн өглөг	98,283,653.00	-	89,852,807.00	89,852,807.00
Татварын өр	312,280,921.39	526,955,594.31	-	526,955,594.31
НДШ-ийн өглөг	-	1,479,306.82	-	1,479,306.82
Ноогдол ашгийн өглөг	1,922,995,264.40	-	1,953,749,327.40	1,953,749,327.40
Бусад богино хугацаат өр төлбөр	97,548,874.00	-	115,765,646.00	115,765,646.00
Нийт дүн	38,835,181,230.40	528,434,901.13	49,368,995,757.89	49,897,430,659.02

Үүнээс дэлгэрэнгүй гүйлгээг харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл 2025.01.01	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл 2025.12.31
Дансны өглөг	5,864,508,504.02	156,008,137.764.23	156,436,070.202.22	6,292,440,942.01
Орлого татвар өглөг	269,483,984.47	256,525.769.17	471,492,853.49	484,451,068.79
Цалин өглөг	98,283,653.00	2,299,828.036.80	2,291,397,190.80	89,852,807.00
ХАОАТатварын өглөг	1,340,334.00			1,340,334.00
НД-ийн шимтгэлийн өглөг	-5,533,451.39	460,244,234.95	467,256,993.16	1,479,306.82
НИИТ ДҮН	6,228,083,024.10	159,024,735.805.15	159,666,217,239.67	6,869,564,458.62

Дансны өглөгийн тооцоог байгууллага нэг бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулах шаардлагатай.

Ноогдол ашгийн өглөг болон урт хугацаат зээлийн тооцоог тодруулан тайланд хугацааны төлбөрийг хугацаанд нь барагдуулан ажиллаж эрсдэлээс сэргийлэн хяналт тавьж байх.

Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Орлогод зөвхөн тухайн бизнесийн үйл ажиллагаанаас хүлээн авсан болоод ирээдүйд хүлээн авах эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал хамаарна. Суутгасан татвар, МАХИМПЕКС ХК-ний 2025 оны санхүүгийн тайлангийн аудит

барааны болон үйлчилгээний хураамж, нэмэгдсэн өртгийн татвар зэрэг гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн өгөөжид хамаарахгүй бөгөөд эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэхгүй. Иймээс эдгээрийг орлогын дүнгээс хасаж тооцдог. Компанийн хувьд орлогын хүлээн зөвшөөрөлт дараах байдалтай байна. Үүнд:

- Бараа борлуулсны орлого

Орлогоос нэмэгдсэн өртгийн албан татварыг хассан дүнгээс худалдааны хөнгөлөлт, буцаалт зэргийг хасаж тооцдог.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1. Бараа, бүтээгдэхүүн борлуулсны орлого	53,175,461,001.63	103,481,660,128.97
Цалингийн зардал	2,428,452,216.00	2,291,397,190.80
НДШ-ийн зардал	327,841,049.16	467,256,993.16
Материалын зардал	45,032,009,709.00	90,070,040,550.95
Тээвэр, шатахууны зардал	60,269,445.30	80,910,868.00
Түрээсийн зардал	-	-
Элэгдэл, хорогдлын зардал	867,454,122.25	490,184,704.49
Бусад	1,180,987,147.69	3,950,914,031.91
2. Борлуулалтын өртгийн дүн	50,697,873,689.40	97,957,310,339.31

Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31		2025.12.31	
	Борлуулалт мартекингийн зардал	Ерөнхий удирдлагын зардал	Борлуулалт мартекингийн зардал	Ерөнхий удирдлагын зардал
Ажиллагчдын цалингийн зардал	256,107,186.00	313,684,036.00	226,395,812.00	344,827,781.00
НДШ-ийн зардал	30,099,743.00	77,939,496.36	22,726,044.85	71,480,092.34
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	-	48,938,601.00	-	103,869,151.70
Томилолтын зардал	-	7,396,821.60	-	1,509,500.00
Бичиг хэргийн зардал	37,695,099.32	-	-	24,414,170.60
Шуудан холбооны зардал	-	5,560,912.35	-	3,934,027.34
Мэргэжлийн үйлчилгээний зардал	-	-	-	-
зардал	-	-	-	1,200,000.00
Сонин өртгүүл зохиолтын зардал	-	-	-	-
Даатгалын зардал	-	-	-	1,212,252.00
Ашиглалтын зардал	-	-	-	18,769,984.72
Засварын зардал	2,824,909.09	5,000,000.00	2,038,181.82	2,096,000.00
Элэгдэл, хорогдлын зардал	-	73,994,828.25	12,269,544.35	67,161,353.29
Түрээсийн зардал	-	-	-	10,963,000.00
Харуул хамгааллын зардал	-	-	-	-
Тээвэрлэлт үйлчилгээний зардал	-	3,530,706.41	-	4,037,459.63
Тээврийн зардал	-	-	-	-
Шатахууны зардал	43,194,304.16	11,944,400.01	23,981,611.48	12,022,771.53
Хүлээн авалтын зардал	-	-	-	-
Зар сурталчилгааны зардал	20,648,981.77	2,022,250.00	126,855.88	4,511,574.00
Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	20,316,330.20	-	21,376,990.38	-
Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	-	-	-	-
Бусад	11,709,364.40	477,817,563.62	243,147,851.29	3,471,968,391.02
НИЙТ ДҮН	422,595,917.94	1,027,829,615.60	552,062,892.05	4,143,977,509.17

МАХИМПЕКС ХК-ний 2025 оны санхүүгийн тайлангийн аудит

14

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Бусад орлого олз	3,607,840,500.92	3,648,529,455.41

Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэгт тайлант үеийн татвар ногдуулах ашиг (алдагдал)-аас тооцсон орлогын албан татварын өглөгийн дүн болон хойшлогдсон татварын өглөг эсвэл хойшлогдсон татварын хөрөнгөөс бүрддэг. Тайлант жилийн татвар нь тухайн жилийн орлогоос хуулийн дагуу тогтоосон татварын хувиар ногдуулсан татварын өглөгийн дүн юм.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1. Тайлант үеийн орлогын татварын зэрдал	233,540,227.04	471,492,353.49

Хойшлогдсон татварын хөрөнгө болон татварын өглөг нь санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгө, эсвэл өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурь хоёрын хоорондох зөрүүнээс үүсдэг. Түр зөрүү нь хоёр хэлбэртэй бөгөөд эдгээр нь зэрэг тодорхойлогдоггүй, аль нэг нь л байна. Үүнд:

- *татвар ногдох түр зөрүү* гэдэг нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогод үүсэх түр зөрүү юм.
- *хасагдах түр зөрүү* гэдэг нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогоос хасагдах дүнгээс үүсэх түр зөрүү юм.

Эздийн өмч

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Тоо ширхэг	2024.12.31	Тоо ширхэг	2025.12.31
1	Эхний үлдэгдэл	9,891	377,820.9	9,891	377,820.9
2	Нэмэгдсэн	0.0	0.0	0.0	0.0
3	Хасагдсан	0.0	0.0	0.0	0.0
4	Эцсийн үлдэгдэл	9,891	377,820.9	9,891	377,820.9

Улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн дүнгээс санхүүгийн тайлангийн дүн /380,072.1-377,820.9/- 2,251.2 мянган төгрөгөөр зөрүүтэй буйг залруулан бүртгэх шаардлагатай байна.

Тус компанийн эзэмшигчдийн өмч нь өөрийн хөрөнгө (дүрмийн сан), эздийн өмчийн бусад хэсэг, өмнөх үеийн болон тайлант хугацааны хуримтлагдсан ашиг, алдагдлаас бүрддэг. 2025 онд 3,992,078,864.94 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Аудитын ажлаар илэрсэн асуудлыг удирдлагын захидлаар танилцуулсан болно.

Аудитаар илгээсэн зөрчил дутагдлыг засан хэрэгжүүлэх ажлын талаар:

1. Татварын тайлангийн авлага, өглөг тооцоог болон банкны харилцах дансны үлдэгдлийг баталгаажуулах дахин хянан үзэх
2. Хөрөнгө оруулалтад бараа материалыг зарцуулж буй байдалд эрсдэлээс сэргийлэн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.
3. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланг гүйлгээ балансын дүнтэй хянах, мөн үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын байдалд үзлэг хийн, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлгээ хийх асуудлыг шийдвэрлүүлэх.
4. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг хуулийн хугацаанд маягтын дагуу чанартай хийж, үр дүнг тооцдог байх.
5. Санхүүгийн тайлангийн эздийн өмчийн дүнг залруулах
6. Авлага, өглөгийг тооцоог НББОУС 24-т "Холбоотой талуудын тодруулга" – д заасны дагуу толгой компанийн нэр, хэрэв хамгийн дээд хяналт тавигч тал нь холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг тодруулах,
7. Мөн тайлант үеийн санхүүгийн тайланд НББОУС 10-т "Тайлагналын үеийн дараах үйл явдал" – ийн дагуу тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал тус бүрийн хувьд мөн чанар, санхүүгийн нөлөөллийн тооцооллыг тодруулна. Хэрэв санхүүгийн нөлөөллийн тооцоолол хийх боломжгүй бол тайлбар, тэмдэглэл хийх гэсэн стандартыг мөрдөх.
8. ТУЗ-ийн аудитын хороо нь компанийн үйл ажиллагааны хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх

Дундманхайдай аудит ХХК:

Аудитор

Мах Импекс ХК:

Зөвшөөрч Танилцсан: Гүйцэтгэх захирал

Нягтлан бодогч

Ж.Бямбажав

Г.Бүдрагчаа

С.Мөнхжаргал

